



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 26 өдөр

Дугаар АА70

Чойр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 60.1.21, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Монгол Улсын сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5, Засаг даргын зөвлөлийн хурлын 2022 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын Байгаль орчны байнгын хорооны гишүүд, Засгийн газрын хамтарсан ажлын хэсэг Чойрын богд уулын улсын тусгай хамгаалалтыг өргөтгөх асуудлыг судалж, шийдвэрлэх ажлаар орон нутагт ажилласантай холбогдуулан хоолны зардалд 970,980 (есөн зуун далан мянга есөн зуун наян) төгрөг зарцуулсугай.

2. Холбогдох зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Г.БАТЗАМ